


БАТЛАВ.
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА



Г.ЧИНЗОРИГ

2021 оны 09 сарын 10-ны өдөр

БАТЛАВ.
"ВОЙД ПЛАС" ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



П.МӨНХ-ЭРДЭНЭ

№ 53/2149

Улаанбаатар хот.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид "ХХЗХ" гэх) түүнийг төлөөлж Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга З.Эрдэнэчулуун (цаашид "Захиалагч" гэх) нөгөө талаас "ВОЙД ПЛАС" ХХК /регистрийн дугаар №6671969, улсын бүртгэлийн дугаар №000219333/ (цаашид "Ажил гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай П.Мөнх-Эрдэнэ нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) Иргэний хуулийн 343 дугаар зүйлийг удирдлага болгон дараах болзол, нөхцөлийг харилцан тохиролцож 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр байгуулав.

1. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.2. Талууд Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын санаачилгыг дэмжиж, Үндэсний соёл амралтын хүрээлэнд 2021 оны 9 дүгээр сарын 17, 18, 19-ны өдрүүдэд зохион байгуулах Харилцаа холбооны салбарын Улсын зөвлөгөөн арга хэмжээ (цаашид "арга хэмжээ" гэх)-д Шууд дамжуулалтын ажил үүргийг гүйцэтгэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход гэрээний зорилго оршино.

2. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР, ХУГАЦАА, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

2.1 Ажил гүйцэтгэгч нь захиалагчийн санхүүжилтээр Харилцаа холбооны салбарын Улсын зөвлөгөөний хүрээнд тайз угсралт, тохижилтын ажлыг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн 2021 оны 9 дүгээр сарын 19-ний арга хэмжээ дуусгавар болтол хийж гүйцэтгэнэ.

2.2 Энэ гэрээний 8.1-д заасан нөхцөл байдал үүсэхээргүй бол ажил гүйцэтгэгч нь уг гэрээний 2.1, дахь заалтыг баримтлан ажиллана.

2.3 Талууд гэрээг дүгнэж, акт үйлдсэнээр гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэнд тооцно.

2.4 Гэрээний төлбөр **19,100,000 /арван есөн сая нэг зуун мянга/ төгрөг байна. Энэ үнэд НӨАТ орсон болно.**

2.5 Захиалагч нь уг гэрээний 2.1 дэх хэсэгт заасан ажлын 100 хувийн төлбөр болох **19,100,000 /арван есөн сая нэг зуун мянга/ төгрөгийг ажил гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.**

Талууд гэрээний хуудаст тусгасан бүх нөхцлийн талаар хүсэл зоригоо илэрхийлж харилцан тохиролцсоны баталгаа болгож гарын үсэг зурав.

..... төлөөлж:

..... төлөөлж: 



2.6 Гэрээний төлбөрийг хүлээн авах дансны мэдээлэл:

a	Гэрээний төлбөр	19,100,000
b	Хүлээн авагчийн нэр	"ВОЙД ПЛАС" ХХК
c	Хүлээн авах банк	Худалдаа хөгжлийн банк
d	Дансны дугаар	436 007 306
e	Валют	MNT

3. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Захиалагч нь дараах эрхийг эдэлнэ.

3.1.1 Ажил гүйцэтгэгчээс ажлын чанар явцын мэдээллийг тухай бүр тодруулах, хяналт тавих эрхтэй.

3.1.2 "тоног төхөөрөмж"-тэй холбоотой гарсан ямар нэг зөрчлийг арилгуулахаар ажил гүйцэтгэгчид шаардлага тавих эрхтэй.

3.1.3 Ажил гүйцэтгэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлаа хэрхэн хангаж ажиллаж байгаа болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах зааварчилгааны хувийг авах эрхтэй.

3.1.4 Ажил гүйцэтгэлийн явц чанарыг шалгаж, шаардлагатай зөвлөгөө, саналыг гаргана.

3.1.5 "Тоног төхөөрөмж"-ийг угсрах, шууд дамжуулалтыг дуу дүрсний өндөр чанартай дамжуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах өөрийн төлөөлөгчийг томилж, аливаа гарч болох алдаанаас урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдалтай ажлын гүйцэтгэлд шаардлага тавьж ажиллана.

3.1.6 Арга хэмжээ болохоос өмнө ажил гүйцэтгэгчээс шууд дамжуулалтын ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой хийгдсэн ажлууд /цагийн менежмент гаргасан хөтөлбөр/-ыг гаргуулан авах эрхтэй.

3.1.7 Ажил гүйцэтгэгчээс хувийн онцлог байдлаа илтгэсэн ялгах тусгай тэмдэг /хувцас, мандат г.м/-тэй байхыг шаардах эрхтэй.

3.1.8 Ажил гүйцэтгэгчээс аюулгүй байдал болон чанарын шаардлага хангасан, дуу дүрсний дамжуулалтыг шаардах эрхтэй.

3.1.9 Ажил гүйцэтгэгчээс орчны өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангаж, паркийн үндсэн үйл ажиллагаанд саад учруулахгүй байдлаар ажиллахыг шаардах эрхтэй.

3.2 Захиалагч нь дараах үүргийг хүлээнэ:

3.2.1 Ажил хийж гүйцэтгэхэд зориулагдсан талбайг гаргаж өгнө.

3.2.2 Арга хэмжээний бэлтгэл ажилтай холбоотой мэдээллээр ажил гүйцэтгэгчийг цаг алдалгүй хангаж ажиллана.

3.2.3 Ажил гүйцэтгэгчийн ажлаа саадгүй явуулахад шаардлагатай талбайн зөвшөөрөл, тог ашиглах зөвшөөрлүүдийг авсан байна.

3.2.4 Өөрсдийн ажилчдын ёс зүйн хэм хэмжээ, сахилга батыг сахин хангана.

4. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

Талууд гэрээний хуудаст тусгасан бүх нөхцлийн талаар хүсэл зоригоо илэрхийлж харилцан тохиролцсоны баталгаа болгож гарын үсэг зурав.

..... төлөөлж:

..... төлөөлж: 



4.1 Ажил гүйцэтгэгчийн эрх

4.1.1 Захиалагч талын ажилчид, арга хэмжээнд оролцож буй уран бүтээлчид, зочид, үзэгчид, туслан гүйцэтгэгч нарын буруутай үйл ажиллагааны улмаас ажил гүйцэтгэгч талын “тоног төхөөрөмж”-ийн хэвийн үйл ажиллагаа (гацах, унтрах) алдагдах тохиолдолд ажил гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй.

4.1.2 Нийлүүлсэн “тоног төхөөрөмж”-ийн чанар болон ашиглалтын шаардлагыг хангасан, биет байдлын доголдолгүй байдлаар гэрээнд заасан хугацаанд түрээсийн зорилгоор ашиглуулна.

4.1.3 Ажил гүйцэтгэгч нь өөрийн “тоног төхөөрөмж”-н хүчин чадлыг тооцоолон үйлчилгээг үзүүлнэ.

4.1.4 Захиалагч арга хэмжээ зохион байгуулахтай холбоотой шаардлагатай мэдээллээр хангахыг шаардана.

4.1.5 Гэрээт ажлыг чанар, стандартын өндөр түвшинд гүйцэтгэнэ.

4.2 Ажил гүйцэтгэгчийн үүрэг

4.2.10 Ажил гүйцэтгэгч нь тоног төхөөрөмж тээвэрлэх, угсрах, зөвлөгөөнийг шууд дамжуулах гэх мэт ажлыг хариуцах ба ажлын үеэр аюулгүй байдлыг хангаж өөрсдийн ажил гүйцэтгэж буй хүмүүстээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /ХАБЭА/-н зааварчилгаа өгч хянаж ажиллана.

4.2.11 Ажил гүйцэтгэгч шууд дамжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсний дараа 2021 оны 9 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд болох арга хэмжээ дуусгавар болсны дараа шууд дамжуулалтын тоног төхөөрөмжийг хураах ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.2.12 Арга хэмжээ болох газарт цахилгааны инженерийг томилоогүй, харуул хамгаалалтыг гаргаагүй, цахилгааны эх үүсвэр доголдолтой буюу техникийн аюулгүй байдлыг хангаагүй тохиолдолд “тоног төхөөрөмж”-г ажиллуулахаас татгалзана.

4.2.13 Ажил гүйцэтгэгч нь хүлээсэн үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ тухай талуудад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд учирсан бэрхшээлийг арилгахын тулд боломжтой бүхий л арга хэмжээг авч ажиллана.

4.2.14 Энэхүү гэрээгээр тохиролцсон хугацаанд ХХЗХ-той гэрээгээр тохирсон ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтыг гүйцэтгэж, актаар тайлагнах ба холбогдох бусад ажил үүргийг мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хийж гүйцэтгэнэ.

4.2.15 Улсын зөвлөгөөн үргэлжлэх хугацааны турш шууд дамжуулалтын хэвийн ажиллагаанд хяналт тавьж, гарсан доголдлыг тухай бүр өөрийн зардлаар арилгана.

4.2.16 Арга хэмжээний зохион байгуулалтыг хариуцан ажиллах тусгай бэлтгэгдсэн арга хэмжээ хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулна.

4.2.17 Өөрсдийн ажилчдын ёс зүйн хэм хэмжээ, сахилга батыг сахин хангана.


4.2.18 Цахилгааны эх үүсвэр, цахилгаан гүйдэл гүйж буй хэсэг, цахилгаан холболтуудын хэсэгт хамгаалалт гаргаж аюулгүй байдлыг хангах ба цахилгааны аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэн гарсан аливаа хохирлыг бүрэн хариуцна.

5. ХАРИУЦЛАГА

Талууд гэрээний хуудаст тусгасан бүх нөхцлийн талаар хүсэл зоригоо илэрхийлж харилцан тохиролцсоны баталгаа болгож гарын үсэг зурав.

..... Төлөөлж:

..... Төлөөлж:



5.1 Захиалагч нь ажил гүйцэтгэгчид төлөх төлбөрийг гэрээний 2.5 дах хэсэгт заасан хугацаанд төлөөгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алдангийг ажил гүйцэтгэгчид төлнө.

5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг (гэрээний үнийн дүнгээс үл хамаарна) хариуцна.

6. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ТАТГАЛЗАН ГАРАХ

6.1 Талууд энэ гэрээ хүчин төгөлдөр болсны дараа гэрээнээс татгалзах, гэрээг үндэслэлгүйгээр цуцлахгүй байхыг эрмэлзэнэ.

6.2 Гэрээ Иргэний хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах нөхцөлөөр дуусгавар болж болно.

6.2.1 Талууд харилцан тохиролцсон.

6.2.2 Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэн.

6.3 Гэрээ Иргэний хуулийн 294 дүгээр зүйлийн 294.2 дахь хэсэгт зааснаас гадна дараах нөхцөлөөр цуцлагдаж болно.

6.3.1 Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхийг удаа дараа шаардуулсан.

6.3.2 Гэрээний үүргийг ноцтой зөрчсөн.

6.3.3 Гэрээний 1-т заасан гол нөхцөл биелэгдээгүй.

7. НУУЦЛАЛ

7.1 Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон харилцан солилцсон мэдээлэл, баримтын нууцлалыг Гэрээ байгуулагдсанаас хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд нөгөө Тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.

7.2 Талуудаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглагдсан мэдээлэл, баримт материал, ноу-хау, оюуны өмч, барааны тэмдэгт хамааралтай мэдээлэл, баримтууд нь тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэнэ.

8. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл /дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал/-ийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийх биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол гэрээг хойшлуулах асуудлыг талууд харилцан тохиролцон шийдвэрлэнэ.

8.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд өртсөн тал нь өөрийн үүрэгт хамаарах үйл ажиллагааг сэргээж гэрээний хэрэгжилтэд гарсан саатлыг аль болох богино хугацаанд арилгахыг эрмэлзэх ба энэ талаар нөгөө талд шуурхай мэдэгдэнэ.

9. БУСАД

Талууд гэрээний хуудаст тусгасан бүх нөхцлийн талаар хүсэл зоригоо илэрхийлж харилцан тохиролцсоны баталгаа болгож гарын үсэг зурав.

..... төлөөлж:

..... төлөөлж:



9.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

9.2 Энэхүү гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд ойлголцох, эвлэрэх зарчмаар асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэх ба тохиролцохгүй тохиолдолд Монгол улсын шүүхээр шийдвэрлэнэ.

9.3 Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.4 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж "Талууд" тус бүр нэг нэг хувийг хадгалах ба гэрээний хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд эдгээр нь хуулийн адил хүчинтэй байна.

9.5 Оролцогч талууд урьдчилан нөгөө талдаа бичгээр мэдэгдэхгүйгээр энэхүү гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн бусдад шилжүүлэх, засварлах, өөрчлөхийг хориглох ба хэрэв зайлшгүй шинэчлэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл талуудын эрх бүхий хүмүүс харилцан тохиролцож уг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО"-Г ТӨЛӨӨЛЖ:


Захиргааны Удирдлага, Хамтын
ажиллагааны газрын дарга


З.ЭРДЭНЭЧУЛУУН

Хуулийн хэлтсийн дарга


Т.УУГАНБАТ

Захиргааны Удирдлага, Хамтын
ажиллагааны газрын мэргэжилтэн


Д.НАРАНСОЛОНГО

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Гүйцэтгэх захирал


П.МӨНХ-ЭРДЭНЭ

Талууд гэрээний хуудаст тусгасан бүх нөхцлийн талаар хүсэл зоригоо илэрхийлж харилцан тохиролцсоны баталгаа болгож гарын үсэг зурав.

..... төлөөлж:

..... төлөөлж: 

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
Гарын үсэг: 
20... он ... Сар...

АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ҮНЭ

Үйлчилгээний төрөл	Тайлбар	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1. Онлайн event				
Live stream	<ul style="list-style-type: none"> * 5 зураглаач, эвлүүлэгч, туслах ажилтан, online хянагч, sound хянагч ажиллана * Хөлтэй, хөдөлгөөнтэй камерууд ажиллана * Илтгэлийн PPT танилцуулгад цахимаар үзүүлэх техникийн шаардлага талаас мэргэжлийн зөвлөгөө өгнө * Онлайн дамжуулалтын бичлэгийг уртаар, чанартайгаар нь хүлээлгэн өгнө * 1-2 удаагийн тест хийгдэнэ 	1	8,500,00 0	8,500,000
Онлайн дамжуулалтын зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> * Сонгосон платформ, хэрхэн дамжуулах, техникийн шаардлага, онлайн техник холболт зэргийг бүрэн хариуцах * Шууд дамжуулалт Лед рүү, онлайн дамжуулалт, хүлээн авах гэх мэт техник холболтуудыг хариуцна * Постер, титр, текст гэх мэт туслах контент материалуудыг бэлдэнэ * Онлайнтай холбоотой зөвлөгөө мэдээллээр хангана 	1	7,690,000	7,690,000
Эвлүүлэг, график	<ul style="list-style-type: none"> * Highlight video * After video * Photo 	1	1,000,000	1,000,000
Нийт үйлчилгээний үнэ				17,190,000
НӨАТ				10%
Нийт үнийн дүн				19,100,000

Талууд гэрээний хуудаст тусгасан бүх нөхцлийн талаар хүсэл зоригоо илэрхийлж харилцан тохиролцсоны баталгаа болгож гарын үсэг зурав.

..... төлөөлж:

..... төлөөлж:

